

“АЛТ-2” ХӨТӨЛБӨРИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА

“Алт-2” хөтөлбөрийн төслийг 2016 оны эхний хагас жилд боловсруулж дуусган холбогдох яамд болон байгууллагуудаас санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэсэн байсан.

Монгол Улсын “Хөгжлийн бодлогын тухай” хуулийг УИХ-аас батлан хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнтэй уялдуулан тухайн хуулийг дагаж мөрдөх нийтлэг журамд нийцүүлэн дахин боловсруулах шаардлагатай болсон билээ.

Энэхүү шаардлагын дагуу хөтөлбөрийн төслийг дахин шинэчлэн боловсруулж эхэлсэн юм. Энэ ажлын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөтөлбөрийн төсөлд хэрэгжүүлэх үе шат, хэрэгжүүлэх арга замыг тодорхой болгож нарийвчилсан.
- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгасан.
- “Алт-2” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнд санал тусгуулахаар 2 удаагийн уулзалтыг УУХҮЯ-ны хурлын танхимд зохион байгуулсан. Эхний уулзалтаар Монголын алт үйлдвэрлэгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүд болон алт олборлогч томоохон 20 ААН-ийн төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулж, төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, ажилд саад болж байгаа хүчин зүйл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар саналыг тусгайлан бэлтгэсэн санал авах хуудсаар авсан. Уулзалтын үр дүнд хууль эрх зүйн тогтворгүй байдал, хөрөнгө оруулалт болон санхүүжилтийн хүндрэлтэй асуудал, алт олборлогч үндэсний томоохон аж ахуйн нэгжүүдийг бий болгох, хүнд суртлыг багасгах саналуудыг гаргасан.

Хоёр дах удаагийн уулзалтыг алтны үндсэн ордын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа 10 гаруй аж ахуйн нэгжүүдийн дунд зохион явууллаа. Уулзалтаар төслийг явуулахад учирч байгаа хүндрэл бэрхшээл, орон нутгийн зүгээс тусгай зөвшөөрлийн эрхийг хүлээн зөвшөөрдөггүй байдал, иргэдийн хөдөлгөөн, хөрөнгө оруулалт, санхүүжилт, хууль эрх зүйн орчинг сайжруулах асуудлаар санал солилцов. Уулзалтын үр дүнгээр алт үйлдвэрлэлийн хууль эрх зүйн орчинг тогтвортой байлгах, орон нутагт үйл ажиллагаа явуулахад учирч байгаа хүнд суртлыг багасгах, аж ахуйн нэгжүүдэд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг тодорхойлж цаашид хууль эрх зүйн орчинг сайжруулахад Ажлын хэсэг байгуулж ажиллахаар санал гаргасан.

“Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулахад алт олборлогчтой уулзсан уулзалтаас гарсан санал хүсэлтүүдийг тусгасан болно.

“Алт-2” хөтөлбөрийн төслийг 2016 онд багтаан боловсруулж дуусган эцсийн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.